



Аудитын код: САГ-2018/406/СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:


Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер С.Оюунгэрэл
Утас: 261885 Цахим хаяг: oyungerels@audit.gov.mn

Аудитор Ц.Энхжаргал
Утас: 261740 Цахим хаяг: enkhjargalts@audit.gov.mn

Гэрээгээр гүйцэтгэсэн: “Лайэн Аудит” ХХК-ийн аудитор: Г.Дэлгэрдэл
Утас: 7012 6778
Цахим хаяг: lionaudit@yahoo.com



Улаанбаатар хот

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн хяналтын болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Нэг. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд “Дулааны техник, үйлдвэрийн экологийн хүрээлэн” УТУГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд САГ-2018/406/СТА-ТШЗ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

“Дулааны техник, үйлдвэрийн экологийн хүрээлэн” УТУГ-ын 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь аудитын байгууллагын үүрэг юм.

“Дулааны техник, үйлдвэрийн экологийн хүрээлэн” УТУГ-ын 2017 оны санхүүгийн тайлангийн аудитыг Үндэсний аудитын газрын захиалгаар 2018 оны 1 дүгээр сарын 29-нөөс 2018 оны 2 дугаар сарын 25-ны хооронд “Лайэн аудит” ХХК-ийн аудитор Г.Дэлгэрцэцэг, аудиторын туслах Ү.Цэнджав нар хийхээр төлөвлөн хэрэгжүүлэв.

“Дулааны техник, үйлдвэрийн экологийн хүрээлэн” УТУГ 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг тус хүрээлэнгийн захирлын 14 тоот албан бичгээр хуулиар тогтоосон хугацаанаас 7 хоног хоцроон 2018 оны 2 дугаар сарын 1-ний өдөр “Лайэн аудит” ХХК-д ирүүлсэн байна.

Хоёр. Байгууллагын хууль, эрх зүйн орчин

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай хууль болон бусад холбогдох хуулиуд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2006 оны 388, 2008 оны 352 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал”-ыг ашиглаж



байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хуульд өөрчлөлт ороогүй байна.

Гурав. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа

“Дулааны техник, үйлдвэрийн экологийн хүрээлэн” /ДТҮЭХ/ УТУГ нь Дулаан масс солилцооны ба шаталтын онол, дулаан хангамж, уурын ба усан халаалтын тогооны хийц технологи, эх орны буюу шинэ материал түүхий эдээр хийсэн бүтээгдэхүүний дулааны физикийн параметруудийг тодорхойлох, нарны энергийг дулаан хангамж, хөргөлтийн системд ашиглана. Мөн эх орны эрчим хүчний үйлдвэрүүдийг зүүн хойд Азийн эрчим хүчний системд зохих байр суурьтайгаар, экологийн баримжаатай хөгжих гарцыг судлах, шаталт, хий шингэний хөдөлгөөний математик загварчлал, оновчлол, хот суурин, үйлдвэрийн экологийн карт зохиох, орон сууц, нийтийн аж ахуй, үйлдвэрийн хатуу хаягдлыг боловсруулан ашиглах технологи, үйлдвэрийн экологийн эдийн засгийн үнэлгээ, мөн энэ чиглэлээр арга зүй, санал боловсруулах зэрэг чиг үүрэгтэй ажилладаг байна.


Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасны дагуу “Дулааны техник, үйлдвэрийн экологийн хүрээлэн” УТУГ-ын захирал төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Аудитын явцад төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Шилэн дансны тухай, Зөрчлийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай, Төрийн хяналт шалгалтын тухай, Татварын ерөнхий хуулиудыг байгууллагынхаа санхүүгийн үйл ажиллагаанд хэрэгжүүлэн ажиллаж байна.

Дөрөв. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын аргазүй, хэрэгжүүлсэн хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар “Дулааны техник, үйлдвэрийн экологийн хүрээлэн” УТУГ-ын 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/



Гүйцэтгэлийн шатанд санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан нийт 18 сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Материаллаг байдлын түвшингийн суурийг тус байгууллагын 2017 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг суурь болгон авч, түүний 2 хувиар тооцон материаллаг байдлын түвшинг 15,609.9 мянган төгрөгөөр тогтоосон болно. /ТАБ-СТА-В-1/

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны А/40 дүгээр тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

“Дулааны техник, үйлдвэрийн экологийн хүрээлэн” УТУГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан, түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

“Дулааны техник, үйлдвэрийн экологийн хүрээлэн” УТУГ-ын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “aculous” програм ашиглан санхүүгийн тайланг боловсруулж гаргасан байна.

Тав. Дотоод хяналтын талаар

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналтын нэгжгүй учир дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Зургаа. Орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

“Дулааны техник, үйлдвэрийн экологийн хүрээлэн” УТУГ 2017 онд Шинжлэх ухаан технологийн сангийн төслөөс 149,966.5 мянган төгрөг, үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 425,121.5 мянган төгрөг нийт 575,088.0 мянган төгрөгийн орлого олж урсгал зардалд 562,743.6 мянган төгрөг зарцуулсан байна.

Долоо. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн болон улс, орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу хангасан эсэх, хуулийн хэрэгжилтийн явцтай танилцахад: Шилэн дансны цахим хуудас www.shilendans.gov.mn-т 2017 оны мэдээллийг оруулаагүй байна.



Найм. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 4 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 18 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Ес. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар

“Дулааны техник, үйлдвэрийн экологийн хүрээлэн” УТУГ-ын 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, цалин болон бараа, ажил үйлчилгээний зардал зэрэг дансдын ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Арав. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар

Аудитын явцад “Дулааны техник, үйлдвэрийн экологийн хүрээлэн” УТУГ-т мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэж гаргах аргачлалын дагуу ажил гүйлгээг бүртгэлд тусгасан байдал, дансны болон ерөнхий журнал, ерөнхий дэвтэр зэрэг хураангуй бичилтийг арга зүйн хувьд нягтлан үзэж санхүүгийн тайлангийн илэрхийлэлд үнэлэлт өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:


1. **Ажлын хөлсний талаар:** Ажил гүйцэтгэх гэрээ байгуулан гэрээ дүгнэсэн актгүйгээр гүйцэтгэгчид төлбөрөө гэрээ байгуулсан өдрөө болон гэрээний хугацаа дуусаагүй байхад 100 хувь шилжүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7-д Захирал нь “тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдөж ажиллах цаашид алдааг давтан гаргахгүй байх талаар зөвлөмж хүргүүлэх.

2. **Гадаад шилжүүлэг:** Гадаад шилжүүлгээр БНХАУ-руу тоног төхөөрөмж материалын үнэ 5,198.6 мянган төгрөг шилжүүлснээ тухайн өдрөө зардалд бүртгэсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх” гэж заасныг зөрчсөн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн



тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7-д Захирал нь “тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдөж ажиллах, цаашид алдааг давтан гаргахгүй байх талаар зөвлөмж хүргүүлэх.

3. **Анхан шатны баримтын талаар:** Шаардлага хангахгүй болон анхан шатны баримтгүй 7,600.0 мянган төгрөгийн ажил гүйлгээг бүртгэж тайланд тусгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-т “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1.2-т “Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөж ажиллах, цаашид алдааг давтан гаргахгүй байх талаар зөвлөмж хүргүүлэх.

4. **Гэрээний талаар:** Огт гэрээгүй, анхан шатны баримтгүйгээр 4,000.0 мянган төгрөгийн ажлын хөлс олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-т “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1.2-т “Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Огт гэрээгүй, анхан шатны баримтгүй олгосон 4,000.0 мянган төгрөгийн ажлын хөлсийг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоох.

Арван нэг. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар

Аудитаар ажил гүйцэтгэх гэрээ байгуулан гэрээ дүгнэсэн актгүйгээр гүйцэтгэгчид төлбөрөө гэрээ байгуулсан өдрөө болон гэрээний хугацаа дуусаагүй байхад 100 хувь шилжүүлсэн, гадаад шилжүүлгээр зөвхөн тоног төхөөрөмж материалын үнэ шилжүүлж тухайн өдрөө зардалд бүртгэсэн, шаардлага хангахгүй болон анхан шатны баримтгүй 7,600.0 мянган төгрөгийн ажил гүйлгээг бүртгэж тайланд тусгасан, огт гэрээгүй, анхан шатны баримтгүйгээр 4,000.0 мянган төгрөгийн ажлын хөлс олгосон зэрэг зөрчлийг залруулах боломжгүй байна.

Арван хоёр. Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Гадаад шилжүүлгээр БНХАУ-руу тоног төхөөрөмж материалын үнэ шилжүүлж тухайн өдрөө зардалд бүртгэсэн, ажил гүйцэтгэх гэрээ байгуулан гэрээ дүгнэсэн актгүйгээр гүйцэтгэгчид төлбөрөө гэрээ байгуулсан өдрөө болон гэрээний хугацаа дуусаагүй байхад 100 хувь шилжүүлсэн, шаардлага хангахгүй болон анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэж тайланд тусгасан зэргийг байгууллагын удирдлага анхаарч анхан шатны баримтын бүрдэл, бэлтгэн нийлүүлэгч болон ажил гүйцэтгэгчтэй байгуулж буй гэрээ болон гэрээний биелэлтийг хянаж баталгаажуулдаг болгох шаардлагатай байна.

Арван гурав. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

“Дулааны техник, үйлдвэрийн экологийн хүрээлэн” УТҮГ-ын авлага, бараа материалын орлого, бэлтгэн нийлүүлэгч болон ажил гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, гэрээний биелэлт, үндсэн хөрөнгийн орлого, элэгдлийн тооцоолол, анхан шатны баримтын талаар дараагийн аудитаар нарийн шалгах шаардлагатай.

Арван дөрөв. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

“Дулааны техник, үйлдвэрийн экологийн хүрээлэн” УТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 25,798.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс 21,798.6 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгч, 4,000.0 мянган төгрөгийн төлбөрийг барагдуулах 1 акт тогтоов.


Арван тав. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

“Дулааны техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэн” УТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг “Тэд аудит” ХХК хийж 6 зөвлөмж өгсөний 5 зөвлөмжийг хэрэгжүүлж, 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Арван зургаа. Зөрчилгүй санал дүгнэлт

“Дулааны техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэн” УТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайланг Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

Аудитын тайланд хавсралт материал /4 хуудас/-ыг хавсаргав.



Хянасан:

Аудитор

Г.Дэлгэрцэцэг

Бэлтгэсэн:

Аудиторын туслах

Ү.Цэнджав

Огноо: 2018.02.26



Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Дулааны техник, үйлдвэрийн экологийн хүрээлэн УТҮГ-ын удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал буюу горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулж болох зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга нь АОУС-ын дагуу хийгддэг Үндэсний аудитын газрын аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан. Энэ нь Дулааны техник, үйлдвэрийн экологийн хүрээлэн УТҮГ-ын хэрэгжүүлдэг нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын зөвлөмжүүд дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Үндэсний аудитын газар эдгээр зөвлөмжийг Та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд харин эдгээр зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Дулааны техник, үйлдвэрийн экологийн хүрээлэн УТҮГ-ын удирдлага, санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

Асуудал 1 Ажлын хөлсний талаар

Тэргүүлэх ач холбогдол № 1

Аудиторын ажиглалт

Ажил гүйцэтгэх гэрээ байгуулан гэрээ дүгнэсэн актгүйгээр гүйцэтгэгчид төлбөрөө гэрээ байгуулсан өдрөө болон гэрээний хугацаа дуусаагүй байхад 100 хувь шилжүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх” гэж заасныг зөрчсөн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7-д Захирал нь “тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Эрсдэлүүд

Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиуд зөрчигдөх.

Зөвлөмжүүд

Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдөж ажиллах.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 7 дугаар сарын 25-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

Асуудал 2 Гадаад шилжүүлгийн талаар

Тэргүүлэх ач холбогдол № 1

Аудиторын ажиглалт

Гадаад шилжүүлгээр БНХАУ-руу тоног төхөөрөмж материалын үнэ 5,198.6 мянган төгрөг шилжүүлснээ тухайн өдрөө зардалд бүртгэсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх” гэж заасныг зөрчсөн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7-д Захирал нь “тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Эрсдэлүүд

Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиуд зөрчигдөх.

Зөвлөмжүүд

Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдөж ажиллах.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 7 дугаар сарын 25-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

Асуудал 3 Анхан шатны баримтын талаар

Тэргүүлэх ач холбогдол № 1

Аудиторын ажиглалт

Шаардлага хангахгүй болон анхан шатны баримтгүй 7,600.0 мянган төгрөгийн ажил гүйлгээг бүртгэж тайланд тусгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-т “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1.2-т “Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Эрсдэлүүд

Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиуд зөрчигдөх, анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэх.

Зөвлөмжүүд

Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдөж ажиллах.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 7 дугаар сарын 25-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

Асуудал 4 Гэрээний талаар

Тэргүүлэх ач холбогдол № 1

Аудиторын ажиглалт

Огт гэрээгүй, анхан шатны баримтгүйгээр 4,000.0 мянган төгрөгийн ажлын хөлс олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-т “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1.2-т “Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Эрсдэлүүд

Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиуд зөрчигдөх, анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэх.

Зөвлөмжүүд

Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдөж ажиллах.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 7 дугаар сарын 25-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

**ДУЛААНЫ ТЕХНИК, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЭКОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН УТУГ-ЫН
АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

2017 оны 12 сарын 31-нээр дуусгавар болсон тайлант жил

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	24,547,629.73	218,996,037.48
МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	11,782,776.71	17,777,184.46
Банкинд байгаа бэлэн мөнгө	11,782,776.71	17,777,184.46
Төгрөг	11,782,776.71	17,777,184.46
Нэмэлт санхүүжилтийн харилцах	11,632,336.17	17,730,861.39
Нэмэлт санхүүжилт арилжааны банк	150,440.54	46,323.07
АВЛАГА	-	12,375,000.00
Бусад авлага	-	12,375,000.00
Байгууллагаас авах авлага	-	12,375,000.00
УРЬДЧИЛГАА	-	174,716,500.00
Урьдчилж гарсан зардал	-	174,716,500.00
БАРАА МАТЕРИАЛ	12,764,853.02	14,127,353.02
Хангамжийн материал	12,764,853.02	14,127,353.02
Бусад хангамжийн материал	12,764,853.02	14,127,353.02
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	846,535,154.72	1,113,376,197.41
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	846,535,154.72	1,113,376,197.41
Биет хөрөнгө	845,816,488.09	1,112,833,530.82
Барилга, байгууламж	790,035,769.00	795,935,769.00
Хуримтлагдсан элэгдэл	- 301,493,196.82	- 324,600,892.01
Машин, тоног төхөөрөмж	476,606,446.95	1,167,976,378.95
Хуримтлагдсан элэгдэл	- 125,009,211.12	- 532,112,008.56
Тавилга, аж ахуйн эд хогшил	24,885,954.00	23,616,916.00
Хуримтлагдсан элэгдэл	- 22,409,274.00	- 21,182,632.68
Бусад үндсэн хөрөнгө	3,000,000.00	3,000,000.00
Хуримтлагдсан элэгдэл	- 229,999.92	- 329,999.88
Номын фонд	430,000.00	530,000.00
Биет бус хөрөнгө	718,666.63	542,666.59
Програм хангамж	1,980,000.00	880,000.00
Хасагдуулга	- 1,261,333.37	- 337,333.41
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	871,082,784.45	1,332,372,234.89
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	-	151,983,313.44
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	151,983,313.44
Өглөг	-	151,983,313.44
Ажиллагчидтай холбогдсон өглөг	-	2,016,813.44
Урьдчилж орсон орлого	-	149,966,500.00
ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	871,082,784.45	1,180,388,921.45
Засгийн газрын хувь оролцоо	871,082,784.45	1,180,388,921.45
Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	266,705,570.00	266,705,570.00
Өмч: - Төрийн өмч	266,705,570.00	266,705,570.00
Хуримтлагдсан үр дүн	461,463,442.45	770,769,579.45
Өмнөх үеийн үр дүн	461,463,442.45	486,213,442.45
Тайлант үеийн үр дүн	-	284,556,137.00
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	142,913,772.00	142,913,772.00
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	871,082,784.45	1,332,372,234.89

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

**ДУЛААНЫ ТЕХНИК, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЭКОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН УТУГ-ЫН
АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН**

2017 оны 12 сарын 31-нээр дуусгавар болсон тайлант жил

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	252,296,425.54	780,494,212.54
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	196,098,425.54	369,772,722.31
Нийтлэг татварын бус орлого	196,098,425.54	369,772,722.31
Төсөвт байгууллагын өөрийн орлого	196,098,425.54	369,772,722.31
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	196,098,425.54	-
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	369,772,722.31
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	56,198,000.00	410,721,490.23
Улсын төвлөрсөн төсвөөс	56,198,000.00	
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	56,198,000.00	
Нэмэлт санхүүжилтийн орлого	-	410,721,490.23
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	410,721,490.23
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	363,509,210.11	495,938,075.54
УРСГАЛ ЗАРДАЛ	363,209,210.11	495,938,075.54
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	363,209,210.11	495,938,075.54
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	115,030,887.00	132,812,184.00
Цалин	114,230,887.00	130,541,184.00
Унаа хоолны хөнгөлөлт	800,000.00	460,000.00
Урамшуулал	-	1,811,000.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,299,514.00	13,910,950.00
Тэтгэврийн даатгалын шимтгэл	8,036,546.00	9,132,402.00
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	913,848.00	1,305,111.00
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,142,309.00	1,044,087.00
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	200,619.00	220,850.00
Эрүүл мэндийн даатгалын хураамж	2,006,192.00	2,208,500.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,369,275.00	23,675,702.00
Гэрэл цахилгааны зардал	13,047,275.00	14,680,702.00
Түлш, халаалтын зардал	16,322,000.00	8,995,000.00
Хангамж, бараа материалын зардал	5,063,555.82	9,165,376.00
Бичиг хэргийн материал	576,455.82	2,310,230.00
Тээвэр, шатахууны зардал	-	1,455,156.00
Шуудан холбоо интернетийн төлбөр	3,326,600.00	2,720,860.00
Ном, хэвлэлийн зардал	1,000,000.00	226,500.00
Хог хаягдал устгах, цэвэрлэх	100,000.00	200,000.00
Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	60,500.00	59,800.00
Аж ахуйн материал худалдан авах зардал	-	2,193,830.00
Нормативт зардал	1,039,000.00	1,368,500.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,039,000.00	1,368,500.00
Эд хогшил, урсгал засварын зардал	105,000.00	1,284,000.00
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	105,000.00	-
Урсгал засвар	-	1,284,000.00
Томилолт, зочны зардал	4,750,943.00	21,901,450.00
Гадаад томилолтын зардал	2,597,100.00	6,139,800.00
Дотоод томилолтын зардал	2,153,843.00	15,761,650.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	27,790,883.00	49,014,476.48
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	25,767,409.60	46,056,552.68
Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	1,800,000.00	2,500,000.00
Газрын төлбөр	186,824.00	186,824.00
Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	36,649.40	271,099.80
Бараа үйлчилгээний бусад зардал	167,760,152.29	242,804,437.06
Бараа үйлчилгээний бусад зардал	94,829,989.90	133,522,757.44
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	640,000.00	
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	72,290,162.39	109,281,679.62
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	300,000.00	
Бусад урсгал шилжүүлэг	300,000.00	
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	300,000.00	
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	- 111,212,784.57	284,556,137.00
НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	- 111,212,784.57	284,556,137.00

**ДУЛААНЫ ТЕХНИК, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЭКОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН УТУГ-ЫН
АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2017 оны 12 сарын 31-нээр дуусгавар болсон тайлант жил

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	257,296,425.54	575,087,990.23
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	201,098,425.54	-
Нийтлэг татварын бус орлого	201,098,425.54	-
Төсөвт байгууллагын өөрийн орлого	201,098,425.54	-
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	201,098,425.54	-
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	56,198,000.00	575,087,990.23
Улсын төвлөрсөн төсвөөс	56,198,000.00	149,966,500.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	56,198,000.00	149,966,500.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	-	425,121,490.23
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	425,121,490.23
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	258,239,536.62	562,743,582.48
УРСГАЛ ЗАРДАЛ	258,239,536.62	562,743,582.48
БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	257,939,536.62	562,743,582.48
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	116,696,089.00	127,569,788.67
Үндсэн цалин	115,896,089.00	125,749,888.67
Унаа хоолны хөнгөлөлт	800,000.00	190,000.00
Үр дүнгийн урамшуулал	-	1,629,900.00
Ажил олгогчоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	12,449,697.00	19,448,100.01
Тэтгэврийн даатгалын шимтгэл	12,449,697.00	19,448,100.01
Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	29,384,125.00	23,675,702.00
Гэрэл цахилгааны зардал	13,062,125.00	14,680,702.00
Түлш, халаалтын зардал	16,322,000.00	8,995,000.00
Хангамж, бараа материалын зардал	3,937,040.00	14,050,376.00
Бичиг хэрэг	260,040.00	2,359,230.00
Тээвэр, шатахуун	-	1,265,156.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,326,600.00	2,720,860.00
Ном, хэвлэл	-	5,726,500.00
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	100,000.00	200,000.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	250,400.00	59,800.00
Аж ахуйн материал худалдан авах зардал	-	1,718,830.00
Нормативт зардал	1,039,000.00	1,638,500.00
Хоол, хүнс	-	270,000.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,039,000.00	1,368,500.00
Эд хогшил, урсгал засварын зардал	105,000.00	1,979,000.00
Багаж техник хэрэгсэл	-	695,000.00
Хөдөлмөр хамгааллийн хэрэгсэл	105,000.00	-
Урсгал засвар	-	1,284,000.00
Томилолт, зочны зардал	4,750,943.00	21,901,450.00
Гадаад албан томилолт	2,597,100.00	6,139,800.00
Дотоод албан томилолт	2,153,843.00	15,761,650.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,679,124.00	39,308,224.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	26,456,000.60	36,350,300.20
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	2,500,000.00
Газрын төлбөр	186,824.00	186,824.00
Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	36,299.40	271,099.80
Бараа үйлчилгээний бусад зардал	62,898,518.62	317,172,441.80
Бараа үйлчилгээний бусад зардал	62,095,098.62	317,172,441.80
Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх	803,420.00	-
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	300,000.00	-
Бусад урсгал шилжүүлэг	300,000.00	-
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	300,000.00	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	-	943,111.08
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	8,345,407.75
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	-	6,350,000.00
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	6,350,000.00
Дотоод эх үүсвэрээр	4,170,000.00	6,350,000.00
Бусад хөрөнгө	4,170,000.00	6,350,000.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-	4,170,000.00
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	5,113,111.08
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	11,782,776.71
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	17,777,184.46



**ДУЛААНЫ ТЕХНИК, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЭКОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН УТУГ-ЫН
АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

2017 оны 12 сарын 31-нээр дуусгавар болсон тайлант жил

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	266,705,570.00	142,913,772.00	572,676,227.02	982,295,569.02
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	266,705,570.00	142,913,772.00	572,676,227.02	982,295,569.02
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Тайлант үеийн үр дүн			- 111,212,784.57	- 111,212,784.57
				-
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	266,705,570.00	142,913,772.00	461,463,442.45	871,082,784.45
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			24,750,000.00	24,750,000.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	266,705,570.00	142,913,772.00	486,213,442.45	895,832,784.45
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Тайлант үеийн үр дүн			284,556,137.00	284,556,137.00
				-
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	266,705,570.00	142,913,772.00	770,769,579.45	1,180,388,921.45

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**